

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2014 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 16/115

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Ухаалаг засаглал", "Цахим эрүүл мэнд" төслүүдийн давхардлыг арилгах, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй шуурхай хүргэх талаар төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Тус ажлын хэсгээс зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг, гүйцэтгэсэн ажил, хэрэгжүүлэх арга хэмжээний талаархи санал, үр дүнг нэгтгэн тайланг Ерөнхий сайдад 2014 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ж.Амарсанаа/-д даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Н.УДВАЛ

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН
ДАРГА

Ц.ЖАДАМБАА

Эрүүл мэндийн сайд, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа
холбооны газрын даргын 2014 оны 01 сарын 15 өдрийн
15/16 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

5202965

Ахлагч

Эрүүл мэндийн дэд сайд Ж.Амарсанаа

Нарийн бичгийн дарга

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа
холбооны газрын дэд дарга З.Энхболд

Гишүүд:

Ерөнхий сайдын Мэдээллийн технологийн зөвлөх
Р.Отгонтулга

Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, дотоод
аудитын газрын дарга С.Төгсдэлгэр;

Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн
газрын дарга Ц.Цолмонгэрэл;

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга
Ч.Бат- Эрдэнэ;

Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, дотоод
аудитын газрын мэргэжилтэн Х.Хүрэлбаатар;

Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн
газрын мэргэжилтэн Б.Мөнхцэцэг;

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа
холбооны газрын Бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын мэргэжилтэн Б.Эрдэнэ;

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа
холбооны газрын Мэдээллийн технологи
инновацийн хэлтсийн мэргэжилтэн
Б.Гэрэлсүрэн;

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа
холбооны газрын Төсөл хөтөлбөрийн хэлтсийн
мэргэжилтэн Э.Алтанбагана;

ЭМШУИС-ийн Мэдээллийн технологийн тэнхимийн
эрхлэгч Б. Баянмөнх

Эрүүл мэндийн сайд, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа
холбооны газрын даргын 2014 оны 11 сарын 15 өдрийн
15/16 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

УХА0514

5202965

Нэг. Зорилго

Монгол Улсад эрүүл мэндийн мэдээллийн системийг боловсронгуй болгон хөгжүүлэх, эрүүл мэндийн мэдээллийн технологи, програм хангамжийн нэгдмэл байдлыг хангах, эрүүл мэндийн мэдээ, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулах

Хоёр. Ажлын хэсгийн гүйцэтгэх ажил

- Дэлхийн банкны санхүүжилттэй “Ухаалаг засаглал” , “Цахим эрүүл мэнд” төслүүдийн төсвийн задаргааг хийх
- Төслүүдийн давхардалд дүн шинжилгээ хийж, давхардлыг арилгах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэхэд шаардлагатай мэдээллийн технологийн төсөл, програм хангамжыг тодорхойлж, эрүүл мэндийн мэдээллийг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах
- Иргэдийн эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах